

## ТАНИЛЦУУЛГА

*Хүнсний гол нэрийн барааны үнэ,  
2014 оны 3-р сарын 26-ны байдлаар*


2014 оны 3-р сарын 26-ны байдлаар хүнсний гол нэрийн барааны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад 3.4 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос 0.1 хувиар буурсан байна.

**Махны дундаж үнэ:** 2014 оны 3-р сарын 26-ны байдлаар хонины ястай махны үнэ өмнөх сарынхаас 7.0 хувь, үхрийн ястай мах 9.1 хувь, үхрийн цул мах 3.8 хувь, адууны мах 1.2 хувь, ямааны мах 3.9 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос үхрийн цул мах 0.5 хувиар буурч, бусад махны үнэ өөрчлөлтгүй байна.

2014 оны 3-р сарын 26-ны байдлаар 1 кг хонины /ястай/ мах дунджаар 7145 төгрөг, үхрийн /ястай/ мах 8480 төгрөг, үхрийн цул мах 9985 төгрөг, адууны мах 6550 төгрөг, ямааны мах 5775 төгрөгийн үнэтэй байв (Зураг 1).

**Зураг 1. Ястай махны жижиглэн худалдааны дундаж үнэ**




**Гурилын үнэ:** 2014 оны 3-р сарын 26-ны байдлаар дээдийн дээд зэргийн савласан гурилын үнэ өмнөх сарынхаас 1.2 хувь, дээд зэргийн савласан гурил 0.9 хувиар өсч, 2-р зэргийн гурилын үнэ 0.4 хувиар буурч, 1-р зэргийн задгай гурилын үнэ өөрчлөлтгүй байна.

Өмнөх 7 хоногийнхоос дээрх төрлийн гурилын үнэ өөрчлөлтгүй байлаа.

**Будаа, элсэн чихрийн дундаж үнэ:** 2014 оны 3-р сарын 26-ны байдлаар элсэн чихрийн үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Цагаан будааны үнэ өмнөх сарынхаас 0.3 хувиар өсч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна. (Зураг 2).

**Зураг 2**



**Төмс, хүнсний ногооны дундаж үнэ:** 2014 оны 3-р сарын 26-ны байдлаар төмс, хүнсний ногооны үнийг өмнөх сарын дундаж үнэтэй харьцуулахад манжин 0.3 хувь, байцаа 2.0 хувь, сонгино 2.3 хувь, лууван 4.2 хувь, төмс 4.9 хувиар өссөн байна.

Өмнөх 7 хоногийнхоос төмс 1.0 хувиар буурч бусад хүнсний ногооны үнэ өөрчлөлтгүй байна.

**Сүү, өндөг, ургамлын болон цөцгийн тосны дундаж үнэ:** 2014 оны 3-р сарын 26-ны байдлаар өмнөх сарынхаас савласан /1 литрийн/ сүүний үнэ 4.0 хувь, "Элекстер" /0.5 л/ савласан сүүний үнэ 2.3 хувиар өсч, задгай сүүний үнэ өөрчлөлтгүй, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Ургамлын тос, цөцгийн тосны үнэ өмнөх сарынхаас болон өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

Өндөгний үнэ өмнөх сарынхаас 0.3 хувиар буурч, өмнөх 7 хоногийнхоос өөрчлөлтгүй байна.

### **Хүнсний гол нэрийн барааны үнэ, аймгаар**

Хүнсний гол нэрийн барааны 7 хоногийн үнийн судалгаанд аймгийн төвүүдээс гурил, мах, цагаан будаа, малын сүү, элсэн чихрийн үнийг судалдаг (Хавсралт хүснэгт 3).

**Гурилын үнэ:** 2014 оны 3-р сарын 26-ны байдлаар аймгийн төвүүдийн хүнсний зах, дэлгүүрт хэрэглээ ихтэй 1-р зэргийн гурилын үнэ 680-1100 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна. Гурилын үнэ өмнөх 7 хоногийнхоос бүх аймагт өөрчлөлтгүй байна.

Дорнод аймагт 1-р зэргийн гурилын үнэ хямд буюу 680 төгрөг байхад, Завхан аймагт 1100 төгрөг байгаа нь өндөр үнэ байна.

**Махны үнэ:** 2014 оны 3-р сарын 26-ны байдлаар хонины махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Завхан, Увс, Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Дундговь, Дархан-Уул, Сэлэнгэ, Хэнтий аймагт 100-800 төгрөгөөр өссөн байна.

Хонины махны үнэ Хөвсгөл аймагт 8500 төгрөг байгаа нь өндөр бөгөөд Баян-Өлгий аймагт 5830 төгрөг байгаа нь хамгийн хямд үнэ байв.

Үхрийн махны үнэ өмнөх 7 хоногийнхоос Баянхонгор, Орхон, Дархан-Уул аймагт 100-530 төгрөгөөр өссөн байна. Үхрийн махны үнэ Дорноговь аймагт 9500 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ бөгөөд Баян-Өлгий аймагт 5500 төгрөгөөр худалдаалагдсан нь хямд үнэ байв.

Ямааны махны үнэ Завхан, Баянхонгор, Орхон, Өвөрхангай, Дундговь аймагт 100-1000 төгрөгөөр өсч, Өмнөговь аймагт 300 төгрөгөөр буурсан байна. Ямааны мах Баян-Өлгий аймагт хямд буюу 5000 төгрөг байхад Өмнөговь аймагт 6500 төгрөг байгаа нь хамгийн өндөр үнэ байна.

**Малын сүүний үнэ:** 2014 оны 3-р сарын 26-ны байдлаар малын сүү аймагт 1100-3000 төгрөгийн үнэтэй худалдаалагдсан байна. Сүүний үнэ Хөвсгөл аймагт 200 төгрөгөөр өсч, Баян-Өлгий, Сэлэнгэ, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт 100-300 төгрөгөөр буурсан байна. Өмнөговь аймагт хамгийн /3000 төг/ өндөр үнэтэй байна.

**Цагаан будаа, элсэн чихрийн үнэ:** 2014 оны 3-р сарын 26-ны байдлаар цагаан будааны үнэ өмнөх 7 хоногийнхоос Дорноговь, Дундговь аймагт 30-200 төгрөгөөр өсч бусад аймагт өөрчлөлтгүй байна. Нийт аймагт цагаан будаа 1 кг нь 1900-2400 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.

Элсэн чихрийн үнэ өмнөх 7 хоногийнхоос Өмнөговь аймагт 140 төгрөгөөр өсч, Дархан-Уул, Дорноговь, Сэлэнгэ аймагт 40-100 төгрөгөөр буурсан байна. Элсэн чихэр 1 кг нь 1500-2000 төгрөгийн хооронд худалдаалагдаж байна.